



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **БНА-2024/170/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Баянхонгор хот  
2024 оны 02 дугаар сар 20

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын  
Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат  
Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn  
Ахлах аудитор М.Алтантуяа  
Утас: 80112188 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn  
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Номгон аудит ХХК  
Захирал Г.Саранчимэг  
Утас: 89891034 Цахим хаяг: audit.nomgon@gmail.com  
Аудитор: О.Мандах Утас: 89010203  
Цахим хаяг: audit.nomgon@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
ӨӨРЧЛӨЛТГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	10
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2 Материаллаг байдал .....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
4.5.1 Завсрын аудитын талаар.....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	15
5.1 Төлбөрийн акт.....	<b>Error! Bookmark not defined.</b>
5.3 Зөвлөмж.....	<b>Error! Bookmark not defined.</b>
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .	<b>Error! Bookmark not defined.</b>

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



Баянхонгор сумын ИТХ-ЫН  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
Ж.БЯМБАСҮРЭН ТАНАА

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2024.02.24 № 49

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

5020342

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 43 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 92.7 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Б.МӨНХБАТ

Баянхонгор сум Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>14,808,848.08</b>	<b>18,589,670.48</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	245,177.48	633,377.48
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	245,177.48	633,377.48
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	186,377.60	00.00
<b>3471</b>	<b>Урьдчилгаа тооцоо</b>	186,377.60	00.00
34713	Цалингийн урьдчилгаа	186,377.60	00.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	14,377,293.00	17,956,293.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	14,377,293.00	17,956,293.00
35410	Бичиг хэргийн материал	663,500.00	1,100,500.00
35420	Аж ахуйн материал	1,597,250.00	1,939,250.00
35430	Сэлбэг хэрэгсэл	00.00	2,800,000.00
35450	Барилгын засварын материал	820,010.00	820,010.00
35470	Бусад хангамжийн материал	11,296,533.00	11,296,533.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>55,481,025.11</b>	<b>36,204,538.42</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	55,481,025.11	36,204,538.42
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	53,709,774.78	35,075,788.01
39203	Авто-тээврийн хэрэгсэл	58,100,000.00	58,100,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-	-
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	22,804,166.83	35,804,166.91
39206	Хуримтлагдсан элэгдэл	27,345,900.00	18,985,900.00
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	-	-
39208	Хуримтлагдсан элэгдэл	14,475,233.45	15,969,733.52
39217	Ном	11,789,340.00	16,999,140.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	-6,719,364.94	-7,708,651.56
39301	Програм хангамж	473,300.00	473,300.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	1,771,250.33	1,128,750.41
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>70,289,873.19</b>	<b>54,794,208.90</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>9,500.00</b>	<b>397,700.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	9,500.00	397,700.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	9,500.00	397,700.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	388,200.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	9,500.00	9,500.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>70,280,373.19</b>	<b>54,396,508.90</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	70,280,373.19	54,396,508.90
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	21,281,230.42	21,281,230.42
51101	Өмч: - төрийн	21,281,230.42	21,281,230.42
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	46,912,116.93	31,028,252.64
51210	Өмнөх үеийн үр дүн	46,912,116.93	46,912,116.93
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	00.00	15,883,864.29
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,087,025.84</b>	<b>2,087,025.84</b>

Баянхонгор сум Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>318,837,600.00</b>	<b>524,868,400.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>318,837,600.00</b>	<b>524,868,400.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	4,306,600.00	3,315,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,306,600.00	3,315,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	314,531,000.00	521,553,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	314,531,000.00	521,553,400.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>323,335,611.30</b>	<b>533,437,264.31</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>323,335,611.30</b>	<b>533,437,264.31</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	309,502,120.45	507,829,543.46
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	109,799,622.86	122,329,438.41
210101	Үндсэн цалин	97,799,622.86	81,896,538.41
210102	Нэмэгдэл	00.00	27,682,900.00
210104	Урамшуулал	12,000,000.00	12,750,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	13,132,203.21	15,210,339.54
210201	Тэтгэврийн даатгал	9,145,589.99	10,392,196.30
210202	Тэтгэмжийн даатгал	1,077,223.00	1,222,611.33
210203	ҮОМШӨ-ний даатгал	861,779.01	1,008,089.04
210204	Ажилгүйдлийн даатгал	176,873.78	223,494.71
210205	Эрүүл мэндийн даатгал	1,870,737.43	2,363,948.16
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	14,121,600.00	20,651,090.80
210401	Бичиг хэрэг	6,019,000.00	12,050,950.00
210402	Тээвэр, шатахуун	6,998,600.00	8,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	882,000.00	600,140.80
210404	Ном, хэвлэл	222,000.00	00.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	10,816,180.00	10,104,700.00
210502	Хоол, хүнс	10,816,180.00	10,104,700.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,312,000.00	1,750,000.00
210604	Урсгал засвар	2,312,000.00	1,750,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	00.00	4,754,000.00
210702	Дотоод албан томилолт	00.00	4,754,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	5,916,348.00	1,220,988.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,259,800.00	934,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	413,800.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	242,748.00	286,488.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	153,404,166.38	331,808,986.71
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	135,938,200.00	314,637,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	17,465,966.38	17,171,286.71
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	13,833,490.85	25,607,720.85
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	7,013,200.00	900,000.00

Баянхонгор сум Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	7,013,200.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	900,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>6,820,290.85</b>	<b>24,707,720.85</b>
213402	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт сумдад	00.00	15,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,820,290.85	24,692,720.85
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-4,498,011.30</b>	<b>-8,568,864.31</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>00.00</b>	<b>7,314,999.98</b>
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	7,314,999.98
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>00.00</b>	<b>-7,314,999.98</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-4,498,011.30</b>	<b>-15,883,864.29</b>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>318,837,600.00</b>	<b>524,868,400.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>318,837,600.00</b>	<b>524,868,400.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	4,306,600.00	3,315,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,306,600.00	3,315,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	314,531,000.00	521,553,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	314,531,000.00	521,553,400.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>310,177,600.00</b>	<b>519,658,600.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>310,177,600.00</b>	<b>519,658,600.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>296,344,109.15</b>	<b>494,350,879.15</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	110,231,177.94	122,143,060.81
210101	Үндсэн цалин	98,231,177.94	81,710,160.81
210102	Нэмэгдэл	00.00	27,682,900.00
210104	Урамшуулал	12,000,000.00	12,750,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	13,132,203.21	15,210,339.54
210201	Тэтгэврийн даатгал	9,145,589.99	10,392,196.30
210202	Тэтгэмжийн даатгал	1,077,223.00	1,222,611.33
210203	ҮОМШӨ-ний даатгал	861,779.01	1,008,089.04
210204	Ажилгүйдлийн даатгал	176,873.78	223,494.71
210205	Эрүүл мэндийн даатгал	1,870,737.43	2,363,948.16
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	14,121,600.00	17,888,090.80
210401	Бичиг хэрэг	6,019,000.00	9,287,950.00
210402	Тээвэр, шатахуун	6,998,600.00	8,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	882,000.00	600,140.80
210404	Ном, хэвлэл	222,000.00	00.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	10,091,880.00	9,908,700.00
210502	Хоол, хүнс	10,091,880.00	9,908,700.00

Баянхонгор сум Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,431,900.00	4,550,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	199,900.00	00.00
210604	Урсгал засвар	2,232,000.00	4,550,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	00.00	4,754,000.00
210702	Дотоод албан томилолт	00.00	4,754,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	5,938,348.00	4,720,988.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,281,800.00	4,431,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	413,800.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	242,748.00	289,988.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	140,397,000.00	315,175,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	140,397,000.00	315,175,700.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>13,833,490.85</b>	<b>25,307,720.85</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	7,013,200.00	600,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,313,200.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	700,000.00	600,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	6,820,290.85	24,707,720.85
213402	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт сумдад	00.00	15,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,820,290.85	24,692,720.85
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>8,660,000.00</b>	<b>5,209,800.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>8,660,000.00</b>	<b>5,209,800.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>8,660,000.00</b>	<b>5,209,800.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	8,660,000.00	5,209,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	8,660,000.00	5,209,800.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-8,660,000.00</b>	<b>-5,209,800.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	21,281,230.42	2,087,025.84	46,912,116.93	70,280,373.19
D01	203 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	21,281,230.42	2,087,025.84	46,912,116.93	70,280,373.19
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	21,281,230.42	2,087,025.84	46,912,116.93	70,280,373.19
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00

Баянхонгор сум Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-15,883,864.29	-
D09	<b>2023 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл</b>	<b>21,281,230.42</b>	<b>2,087,025.84</b>	<b>31,028,252.64</b>	<b>54,396,508.90</b>

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	521,553,400.0	496,860,679.2	24,692,720.9	95.3
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	521,553,400.0	496,860,679.2	24,692,720.9	95.3
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	520,953,400.0	496,260,679.2	24,692,720.9	95.3
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	132,915,400.0	122,143,060.8	10,772,339.2	91.9
210101	Үндсэн цалин	91,850,300.0	81,710,160.8	10,140,139.2	89.0
210102	Нэмэгдэл	27,682,900.0	27,682,900.0	00.0	100.0
210104	Урамшуулал	13,382,200.0	12,750,000.0	632,200.0	95.3
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	16,746,300.0	15,210,339.5	1,535,960.5	90.8
210201	Тэтгэврийн даатгал	11,361,200.0	10,392,196.3	969,003.7	91.5
210202	Тэтгэмжийн даатгал	1,343,400.0	1,222,611.3	120,788.7	91.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,077,800.0	1,008,089.0	69,711.0	93.5
210204	Ажилгүйдлийн даатгал	269,500.0	223,494.7	46,005.3	82.9
210205	Эрүүл мэндийн даатгал	2,694,400.0	2,363,948.2	330,451.8	87.7
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	18,298,500.0	17,888,090.8	410,409.2	97.8
210401	Бичиг хэрэг	9,416,500.0	9,287,950.0	128,550.0	98.6
210402	Тээвэр, шатахуун	8,000,000.0	8,000,000.0	00.0	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	882,000.0	600,140.8	281,859.2	68.0
2105	<b>Нормативт зардал</b>	10,092,000.0	9,908,700.0	183,300.0	98.2
210502	Хоол, хүнс	10,092,000.0	9,908,700.0	183,300.0	98.2
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	11,649,900.0	9,759,800.0	1,890,100.0	83.8
210602	Тавилга	7,099,900.0	5,209,800.0	1,890,100.0	73.4
210604	Урсгал засвар	4,550,000.0	4,550,000.0	00.0	100.0
2107	<b>Томиллолт, зочны зардал</b>	5,850,000.0	4,754,000.0	1,096,000.0	81.3
210702	Дотоод албан томиллолт	5,850,000.0	4,754,000.0	1,096,000.0	81.3
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,170,000.0	1,420,988.0	749,012.0	65.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,132,000.0	1,131,000.0	1,000.0	99.9
210803	Даатгалын үйлчилгээ	592,000.0	00.0	592,000.0	00.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	380,000.0	289,988.0	90,012.0	76.3

**Баянхонгор сум Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	66,000.0	00.0	66,000.0	00.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>323,231,300.0</b>	<b>315,175,700.0</b>	<b>8,055,600.0</b>	<b>97.5</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	323,231,300.0	315,175,700.0	8,055,600.0	97.5
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>600,000.0</b>	<b>600,000.0</b>	<b>00.0</b>	<b>100.0</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>600,000.0</b>	<b>600,000.0</b>	<b>00.0</b>	<b>100.0</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.0	600,000.0	00.0	100.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>521,553,400.0</b>	<b>496,860,679.2</b>	<b>24,692,720.9</b>	<b>95.3</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>521,553,400.0</b>	<b>496,860,679.2</b>	<b>24,692,720.9</b>	<b>95.3</b>
132001	Орон нутгийн төсвөөс	521,553,400.0	496,860,679.2	24,692,720.9	95.3
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>5.0</b>	<b>5.0</b>	<b>00.0</b>	<b>100.0</b>
620001	Удирдах ажилтан	2.0	2.0	00.0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	3.0	3.0	00.0	100.0
620003	Үйлчлэх ажилтан	0	0	00.0	100.0
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>5.0</b>	<b>5.0</b>	<b>00.0</b>	<b>100.0</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	1.0	1.0	00.0	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТУ)	3.0	3.0	00.0	100.0
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	1.0	1.0	00.0	100.0

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**/төгрөгөөр/**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>4,306,600.00</b>	<b>3,300,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,306,600.00</b>	<b>3,300,000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>4,306,600.00</b>	<b>3,300,000.00</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>4,306,600.00</b>	<b>3,300,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,306,600.00	3,300,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>4306600.00</b>	<b>3300000.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>4,306,600.00</b>	<b>3,300,000.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,306,600.00	3,300,000.00

**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

**3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Тус байгууллага нь “Ардчилсан нийгэм дэх зах зээлийн эдийн засгийн харилцааны орон нутгийн удирдлагын үйл ажиллагааг нийцүүлэн орон нутгийн бие даасан хөгжлийг хангах, Монгол улсын Үндсэн Хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон бусад хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрх, чиг үүргийг хэрэгжүүлж сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх бодлогыг зүй зохистой тодорхойлон түүнийг хэрэгжүүлэхэд сумын иргэдийн бүтээлч, санаачилга, идэвхтэй оролцоог нэмэгдүүлэх, сумын Засаг дарга түүний Тамгын газар, төр орон нутгийн өмчит байгууллагуудын үйл ажиллагааг эрчимжүүлэн чанаржуулж төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах, тэдний язгуур, эрх

ашгийг дээдлэн аж байдлыг хэлбэрэлтгүй нэмэгдүүлэн нутгийн өөрийн удирдлагын чадавхыг дээшлүүлэх” гэсэн зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг.

### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Баянхонгор сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь дотоод аудитын нэгж байхгүй бөгөөд санхүүгийн үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт дотоод аудитын алба хяналт, шалгалт хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Аймгийн СТСХ-ээс гаргасан “Нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг” нь мөрдөж байгаа холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Баянхонгор сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Баянхонгор сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 54,794.2 мянган төгрөг болж өмнөх оноос 15,495.9 мянган төгрөгөөр буюу 22.0 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0.0
Авлага	431.6	633.4	201.8
Бараа материал	14,377.3	17,956.3	3,579.0
Үндсэн хөрөнгө	100,383.5	972,33.3	-3,150.2
хуримтлагдсан элэгдэл	-44,902.5	-61,028.8	-16,126.3
<b>Нийт хөрөнгө</b>	<b>70,103.5</b>	<b>54,794.2</b>	<b>-15,309.3</b>
Өр төлбөр	9.5	397.7	388.2
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	<b>70,280.4</b>	<b>54,396.5</b>	<b>-15,883.9</b>
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>70,289.9</b>	<b>54,794.2</b>	<b>-15,495.7</b>

Эх сурвалж: Байгууллагын 2023 оны санхүүгийн тайлан

Авлага дансны үлдэгдэл тайлант оны эцэст 633.4 мянган төгрөг болж өмнөх оноос 201.8 мянган төгрөгөөр өссөн нь ХХОАТ-ын зардлыг дутуу тооцож шилжүүлсэнтэй холбоотой үүссэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 1,7856.3 мянган төгрөг болж 3.150.2 мянган төгрөгөөр өссөн нь 2,800.0 мянган төгрөгөөр сэлбэг хэрэгсэл худалдаж авсан нь голлох нөлөө үзүүлсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 97,233.3 мянган төгрөг болж өмнөх оноос 8,360.0 мянган төгрөгөөр буурсан нь принтерийг Баянхонгор сумын ИТХ-ын 2023 оны 03 сарын 31 өдрийн 9/59 тоот тогтоолоор Баянхонгор сумын ЗДТГ-т шилжүүлэн өгсөнтэй холбоотой байна.

Өр төлбөрийн данс нь 407.2 мянган төгрөгөөр өмнөх оноос өссөн НДШ-ын буруу тооцож дутуу шилжүүлсэнтэй холбоотой байна

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 54,396.5 мянган төгрөг болж 15,883.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурснаас шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 351,145.8 мянга, нийт зарлагыг 351,145.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 170,407.5 мянган төгрөгөөр өсөж 521,553.3 мянган төгрөг болгож нэмэгдүүлэн баталсан байна.

Энэ нь тус төлөөлөгчийн үйл ажиллагааны зардлыг 102,775.2 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 70105 хөтөлбөрийн 80101, 80802, 80825, 82201 арга хэмжээг санхүүжүүлэхээр 521,553.4 мянган төгрөгийн төсөв

Баянхонгор сум Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

батлагдсанаас 521,553.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 521,553.4 мянган төгрөгийн санхүүжилт авч оны эцэст 24,692.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 496,860.6 мянган төгрөг буюу 95.2 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 24,692.7 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Хөтөлбөр	Нэр	/мянган төгрөгөөр/		
			Зарцуулах эрх	Төсвийн гүйцэтгэл	Төсвийн хэлбэлзэл
1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	425,766.60	407,164.93	18,601.67
2	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	600.00	600.00	0
3	80825	Багийн ИНХ-ын даргын урамшуулал	15,186.80	14,304.75	882.05
4	82201	Гэмт хэргээс урьдчилан сэргийл	80,000.00	74,791.00	5,209.00
Нийт			521.55	496.86	24.69

Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд байгууллагын нэмэлт санхүүжилтийн 100030050401 тоот дансанд хамтарсан багийн 3,300.0 мянга, хэвлэмэл хуудасны төлбөр 15.0 мянга, орлого нийт 3,315.0 мянган төгрөг төвлөрүүлж оны эцэст 15.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 3. Нэмэлт санхүүжилтийн орлого

№	Орлогын төрөл	/мян.төгрөгөөр/
		Авсан санхүүжилт
1	Хамтарсан багийн санхүүжилт	3,300.0
2	Хэвлэмэл хуудасны төлбөр	15.0
Нийт		3,315.0

Эх сурвалж: Нэмэлт санхүүжилтийн дансны хуулга

Хүснэгт 4. Нэмэлт санхүүжилтийн зарлага

№	Гүйлгээний утга	/мян.төгрөгөөр/
		Зарлага
1	Баянхонгор сумын 1-10 багын Хамтарсан багуудад дэмжлэг үзүүлэх	3,300.0
Нийт		3,300.0

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан

гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Номгон аудит ХХК-ийн захирал Г.Саранчимэг гүйцэтгэж, хяналтыг Баянхонгор аймаг дахь төрийн ахлах аудитор М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн

Баянхонгор сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 04 дүгээр сарын 19-ны өдрийн 172 дугаар албан бичгээр ирүүлсэн.

2023 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Баянхонгор сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга Ж.Бямбасүрэн, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Г.Лхамжав нар зурж байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн нийт зардлыг сонгож, материаллаг байдлын түвшин 1 хувиар тооцож материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлын 533,437.2 мянган төгрөгөөс 5,248.6 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75 хувиар буюу 3,936.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Тухайн байгууллага нь Төрийн хэмнэлтийн хуулийг баримтлан ажилласан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 499,955.3 мянган төгрөгийн 20

гүйлгээ, зарлагын 201,014.0 мянган төгрөгийн 18 гүйлгээ өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой шийдвэрүүдийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн. Хугацаандаа мэдээлсэн 107, хугацаа хоцорсон 6 мэдээлэл байгаа нь СХАА-наас хийсэн шилэн дансны хяналт шалгалттай холбоотой засвар хийсэнтэй холбоотой болно.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгээгүй.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 20,525.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс санхүүгийн аудитын 20,525.0 мянга, нийцлийн аудитын 0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 4 заалт бүхий зөвлөм, 186.4 мянган төгрөгийн төлбөрийн актыг тогтоож хүргүүлсэн байна. Дээрх зөвлөмжийн биелэлтийг Баянхонгор сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023.04.19-ны өдрийн 172 тоот албан бичгээр ирүүлж хэрэгжилтийг тооцсон байна.

Хүснэгт 5. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	186.4	1	186.4	100
Албан шаардлага	0	0	0	0	0
Зөвлөмж	4	20,338.6	4	20,338.6	100
Нийт дүн	4	20,525.0	4	20,525.0	100

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

оОо